



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Г Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Г

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарын хэмжээнд 2021 оныг “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1. Журмын 2.1.6 дахь заалтын “танилцуулж виз авна.” гэсний өмнө, 2.1.11 дэх заалтын “төвийн захиралд” гэсний дараа “цахимаар” гэж тус тус шинээр нэмсүгэй.

1.2. Журмын 2.1.8 дахь заалтын “боловсруулсан ажилтан холбогдох засварыг тусгаж, анхны төслийг хавсаргана.” гэснийг “хариуцсан ажилтан холбогдох засварыг тусгана.” гэж, 2.1.16 дахь заалтын “заавал танилцуулна.” гэснийг “цахимаар мэдээлнэ.” гэж, 2.2.4 дэх заалтын “боловсруулсан ажилтан холбогдох засварыг тусгаж хэвлэнэ.” гэснийг “хариуцсан ажилтан холбогдох засварыг тусгана.” гэж, 2.2.5 дахь заалтын “2.12-т” гэснийг “2.1.12-т” гэж, 4.1 дэх заалтын “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” гэснийг “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” гэж, 4.2 дахь заалтын “Архивын тухай хууль” гэснийг “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль” гэж тус тус өөрчилсүгэй.

1.3. Журмын “1.4. Хариуцсан ажилтан Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 1.7-д заасан үүрэг хүлээнэ.” гэснийг “1.4.Хариуцсан ажилтан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.4, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 1.7-д заасан үүргийг хүлээнэ.”, 2.1.15 дахь заалтын “Тушаалын эх хувь болон хуулбар хувь олгосон бүртгэлээр холбогдох ажилтанд шилжүүлнэ.” гэснийг “компьютерт мэдээлэл оруулах төхөөрөмж /скайнер/-өөр оруулж PDF өргөтгөлд хөрвүүлж холбогдох ажилтанд цахимаар шилжүүлнэ.”, 2.1.18 дахь заалтын “тухай бүр тайлагнаж, биелэлтийг сар бүрийн 30-ны дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан ажилтанд гаргаж өгнө.” гэснийг “тухай бүр болон заасан хугацаанд тайлагнана.” гэж, “6.2.“Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 1.4.1-д заасан эрхийг хариуцсан ажилтан эдэлнэ.” гэснийг “6.2.Төвийн удирдлага болон хариуцсан ажилтан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж, мөн хуулийн 24.1-д заасан үүргийг хүлээнэ.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

000773

1.4. Журмын 2.1.7 дахь заалтын “цаасан болон”, 2.1.12 дахь заалтын “боловсруулсан ажилтнаас тушаалын төслийг цахим хэлбэрээр авч,” 2.2.4 дэх заалтын “Ингэхдээ анхны болон дараагийн төслүүдийг хавсаргана.” 3.13 дахь заалтын “, амаар” гэснийг болон 2.1.9, 3.2 дахь заалтыг тус тус хассугай.

2. Тушаалыг нийт ажилтанд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /И.Банзрагч/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ